



“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ш.БАЯНМӨНХ



“УСТ БЭЛЧИР” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ

Ш.МӨНХТУЛГА

### АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2022 оны 02 сарын 22-ны өдөр

№ 16/2022

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас “Амгалан дулааны станц” ТӨХК /РД:6021646, цаашид “Захиалагч” тал гэх/, нөгөө талаас “Уст бэлчир” ХХК /РД:6436048, цаашид “Гүйцэтгэгч” тал гэх/- /цаашид хамтад нь “Талууд” гэх/ Иргэний тухай хуулийн 343-358 дугаар зүйл, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34.2.5, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 18.5, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх журам”-ыг үндэслэн дараах нөхцөлөөр энэхүү гэрээг байгуулав.

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь захиалагч талын гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийх ажил гүйцэтгэх, ажлын үр дүнг хүлээлгэн өгөх, гэрээнд заасан ажлын хөлсийг төлөх, гэрээний нөхцөл, талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлага болон үүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2. Гэрээ байгуулагч талууд харилцан үүрэг хүлээж, хамтын зорилгоо хэрэгжүүлж ажиллах үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль тогтоомж, хоёр байгууллагын үндсэн чиг үүрэг, дүрэм, журамд нийцсэн байна.

1.3. Гэрээ байгуулагч талууд хоёр талын нийтлэг зорилгыг биелүүлэхээр хамтран ажиллахдаа бизнесийн болон үйл ажиллагааны нууцыг хэн нэгэнд мэдээлэхгүй, задруулахгүй, хууль бусаар ашиглахгүй шударга байх зарчмыг баримтлана.

#### Хоёр. Гэрээний хугацаа

2.1. Ажил гүйцэтгэх хугацааг хоёр тал харилцан тохиролцож тогтоох бөгөөд хуанлын тооллыг удирдлага болгоно.

2.2. Тухайн байгууллагын гамшгийн эрсдэлийн үнэлгээг ажлын 30 хоногт багтаан гүйцэтгэнэ. Зайлшгүй шаардлагаар хугацаа сунгах тохиолдолд аль нэг тал нь нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэнэ.

2.3. Гэрээний хугацаанд өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

2.4. “Гүйцэтгэгч” талаас гаргах гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайлангийн хугацаанд онцгой байдлын байгууллагын мэргэжлийн зөвлөлөөс гаргах дүгнэлтийн хугацаа орохгүй бөгөөд засвар орсон тохиолдолд гүйцэтгэгч тал тайланд нэмэлт өөрчлөлтийг оруулж өгөх үүргийг хүлээнэ.

2.5. “Гүйцэтгэгч” талаас “Захиалагч” талд гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайланг дуусган хүлээлгэж өгснөөр талууд төлбөр тооцоогоо (онцгой байдлын байгууллагын мэргэжлийн зөвлөлөөс гаргах дүгнэлт хамаарахгүй) бүрэн дуусгана.

#### Гурав. Ажлын хөлс төлбөр тооцоо

3.1. Гэрээгээр гүйцэтгэх объектын гамшгийн эрсдэлийн үнэлгээний ажлын нийт хөлс 16,500,000 төгрөг (арван зургаан сая таван зуун мянга) болно.

3.2 “Гүйцэтгэгч” талын ажлын хөлсний зардал болох 16,500,000 төгрөг (арван зургаан сая таван зуун мянга)-ийг гэрээ дүгнэсэн актаар “Захиалагч” тал хүлээн авч нэхэмжлэлийн дагуу шилжүүлнэ.

#### **Дөрөв. Захиалагч талын эрх, үүрэг**

4.1. Гүйцэтгэгчээс шаардсан гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийхтэй холбоотой мэдээ, мэдээллийг тухай бүрт нь гаргаж өгөх, хэрэв шаардлагатай мэдээ мэдээллийг гаргаж өгөөгүй хугацаа алдсан бол тухайн хариуцлагыг өөрсдөө хүлээнэ.

4.2. Үнэлгээнд хамрагдах объектуудын удирдах ажилтанд холбогдох мэдээ, мэдээллээр шуурхай хангаж, харилцан хамтран ажиллах талаар чиглэл өгсөн байх.

4.3. Захиалагч нь гэрээнд заасан ажлын төлбөрийг гүйцэтгэгчид хугацаанд нь бүрэн төлөх үүрэг хүлээнэ.

4.4. Эрсдэлийн үнэлгээний тайланг хянан үзээд хүлээн авах боломжгүй, шаардлага хангахгүй гэж үзвэл дахин үнэлгээ хийлгэх эрхтэй.

4.5. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний ажлын даалгаврыг гүйцэтгэгч талтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр боловсруулна.

#### **Тав. Гүйцэтгэгч талын эрх, үүрэг**

Гамшгийн эрсдэлийн үнэлгээг дараах төрлөөр хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Объектын гал түймрийн эрсдэлийн үнэлгээ
- Химийн ослын эрсдэлийн үнэлгээ
- Үерийн эрсдэлийн үнэлгээ
- Хүчтэй салхи, шуурганы эрсдэлийн үнэлгээ
- Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээ
- Хүний гоц халдварт өвчний эрсдэлийн үнэлгээ

5.1. Гамшгийн эрсдэлийн үнэлгээг гэрээнд заасан хугацаанд хийж гүйцэтгэнэ.

5.2. Гүйцэтгэсэн ажил нь чанарын шаардлага хангахгүй бол дахин хийж өгөх үүрэг хүлээнэ.

5.3. Гүйцэтгэсэн ажлын үр дүнг захиалагч талын зөвшөөрөлгүй бусдад тайлагнах эрхгүй.

5.4. Гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй, дамжуулахгүй, ажлыг биечлэн гүйцэтгэнэ.

5.5. Гамшгийн эрсдэлийн үнэлгээнд шаардлагатай материалыг гаргаж өгөхийг захиалагч талаас шаардан гаргуулах эрхтэй.

#### **Зургаа. Талуудын хүлээх хариуцлага**

6.1. Ажил “Гүйцэтгэгч” тал нь гэрээнд заасан ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй, захиалагч ажлын төлбөрийг хугацаанд нь төлөлгүй хэтрүүлсэн хоног тутамд 0.1 хувийн алданги тооцно.

6.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас учирсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

6.3. Энэхүү гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг захиалагч талаас Хяналтын хэлтсийн дарга П.Зоригоо (99093763), гүйцэтгэгч талаас мэргэжилтэн Ч.Туяа (99809004) нар хариуцан ажиллана.

#### **Долоо. Давагдашгүй хүчин зүйл**

7.1. Энэхүү гэрээг байгуулсны дараа давагдашгүй хүчин зүйл (*тухайлбал: үер, ган, зуд, хүчтэй салхи шуурга, гал түймэр, газар хөдлөлт, хүн, мал амьтны гоц халдварт өвчний тархалт (коронавирус халдвар болон бусад), хортон шавьж мэрэгч тархах, цацраг идэвхит болон химийн хорт бодис алдагдах, дэлбэрэлт болох, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, оролцоо гэх мэт*)-ийн нөхцөл байдал, шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас аль нэг тал болон



талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг харгалзан хойшлуулж болно.

7.2. Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн тохиолдолд талууд нэн даруй албан бичгээр мэдэгдэнэ.

7.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлөөс шалтгаалан учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгдөнө.

#### Найм. Бусад заалт

8.1. “Захиалагч” болон “Гүйцэтгэгч” талууд гэрээг байгуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчлэх болно.

8.2. Хэрэв талуудын хооронд маргаан гарвал үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

8.3. Гэрээг 2 хувь үйлдэж талууд хадгална.

8.4. Гэрээг гуравдагч этгээдэд ашиглуулахыг хориглоно.

#### Ес. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, түүнийг цуцлах

9.1. Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

9.2. Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

##### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“Амгалан дулааны станц” ТӨХК-ийн Санхүү  
ЭЗ-ийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий  
нягтлан бодогчийн ажил үүргийг түр орлон  
гүйцэтгэгч



Ө.Удвал

Хангамжийн хэлтсийн дарга



Г.Эрдэнэбилэг

Хяналтын хэлтсийн дарга



П.Зоригоо

Хуулийн мэргэжилтэн




Г.Саруул

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8  
дугаар хороо, УС-15 1-1 тоот  
Утас: 77111251

##### АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“Уст бэлчир” ХХК-ийг төлөөлж  
мэргэжилтэн



Ч.Туяа

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүргийн  
17 дугаар хороо, Амарсанаагийн гудамж  
“НДН бизнес төв”-ийн 305 тоот  
Утас: 88031050, 99809004